



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

Нэр бүхий 4 банк бус санхүүгийн байгууллагын  
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий 4 банк бус санхүүгийн байгууллагын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаж, энэ талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдээгүй тохиолдолд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг хавсралтад дурдсан нэр бүхий 4 банк бус санхүүгийн байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2020 оны 03-р сарын 11-ны өдрийн  
112 -р тогтоолын хавсралт



| № | Банк бус санхүүгийн<br>байгууллагын нэр        | Регистрийн<br>дугаар | Үйл ажиллагааны төрөл           |
|---|--|----------------------|---------------------------------|
| 1 | “Актив капитал ББСБ” ХХК                       | 5865778              | Зээл                            |
| 2 | “Бүрэн капитал ББСБ” ХХК                       | 5958938              | Зээл                            |
| 3 | “Монголиагонконг финанс корпораци ББСБ”<br>ХХК | 5059364              | Зээл, гадаад валютын<br>арилжаа |
| 4 | “Топ финанс ББСБ” ХХК                          | 2843927              | Зээл                            |